

**БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГЫГ СОНГОХ ТУХАЙ  
АСУУДЛААР БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН  
БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2017 оны 12 дугаар  
сарын 20-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд зэ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх тухай асуудлыг Байнгын хороо 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцэж Улсын Их Хурлын гишүүн Л.Элдэв-Очирыг Байнгын хорооны даргад нэр дэвшүүлж байна.

Л.Элдэв-Очир нь 1964 онд Улаанбаатар хотод төрсөн. Эхнэр, 4 хүүхдийн хамт амьдардаг. Тэрээр 1981 онд Нийслэлийн 41 дүгээр дунд сургууль, 1986 онд Политехникийн дээд сургуулийг цахилгааны инженер мэргэжлээр төгссөн, цахилгааны систем мэргэжлээр магистр зэрэгтэй. 1986–1991 онд Эрчим хүчний барилга угсралтын трест, конторт монтёр, мастер, инженер, ерөнхий инженер зэрэг албан тушаалыг хашиж байсан. 1992–1996 онд "Mon star" ХХК-ийн дэд захирал, 1996–1998 онд "MCS international" ХХК-ийн дэд захирал, 1998–2003 онд "Спирт Бал Бурам" ХК-ийн ерөнхий захирал, 2003–2008 онд "ZHT & MCS distribution" ХХК-ийн гүйцэтгэх захирал, 2003–2012 онд "MCS групп" ХХК-ийн дэд ерөнхийлөгч, 2010–2012 онд Монгол Улсын Ерөнхий Сайдын зөвлөх, 2012–2013 онд Канад Улс дахь Монгол Улсын Элчин Сайдын яаманд "Элчин зөвлөх"-өөр тус тус ажиллаж байсан бөгөөд 2016 оноос Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдон ажиллаж байна.


Байнгын хорооны хуралдааны үед гишүүд нэр дэвшигчээс асуулт асууж, санал гараягүй бөгөөд Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Л.Элдэв-Очирыг нэр дэвшүүлснийг хуралдаанд оролцсон гишүүдийн дийлэнх олонхи дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд зэ,

Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бухнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярланаа.

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,  
ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА**



Ц.ГАРАМЖАВ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2017 оны 12 дугаар  
сарын...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар  
хот

**Байнгын хорооны даргыг сонгох тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3, 22.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

- 1.Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Лхагваагийн Элдэв-Очирыг сонгосугай.
- 2.Улсын Их Хурлын гишүүн Цэдэнгийн Гарамжавыг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.
- 3.Энэ тогтоолыг баталсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг